

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

| | |
|--|------------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | <i>1</i> |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | <i>1-2</i> |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | <i>3-5</i> |

| | |
|---|-----|
| 1. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ | 3-5 |
|---|-----|

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 09 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь, С.Бямбацогт, Г.Ганболд, Б.Пүрэвдорж, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Эрдэнэбат.

Нэг. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч дарга П.Сайнзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Барилга хөгжлийн төвийн Хот байгуулалт, зураг төслийн институтийн эрхлэгч О.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн асан, Техникийн ухааны доктор, ажлын хэсгийн гишүүн Н.Тогтох, Монгол Улсын Их сургуулийн профессор, Шинжлэх ухааны доктор Р.Ринчинбазар, “Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэг”-ийн захирал Д.Пүрэвбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Н.Энхболд үг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 07 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
13 цаг 09 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 06 сарын 05-ны өдрийн хуралдаанд гишүүд олонх нь хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ. Засгийн газар 24 оны 05 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн асуудал байгаа.

Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цогтгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал, Нийслэлийн Засаг даргын орлогч Сайнзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр, мөн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Балчинлуvsан, мөн яамны Макро

эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан, Эрчим хүчний яамны газрын дарга Ерэн-Өлзий, Зам, тээврийн хөгжлийн яамны газрын дарга Болор-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны газрын дарга Цэрэндулам, Барилгын хөгжлийн төвийн Хот байгуулалт, зураг төслийн институтийн эрхлэгч Одбаяр, Их Хурлын гишүүн асан, Техникийн ухааны доктор, ажлын хэсгийн гишүүн Тогтох, МУИС-ийн профессор Ринчинбазар, Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэгийн захирал Пүрэвбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны ахлах шинжээч Мөнхжаргал, Зам, тээврийн хөгжлийн яамны шинжээч Батцэцэг, Соёлын яамны хэлтсийн дарга Батхуяг, Барилга, хот байгуулалтын яамны газрын дарга Батболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны газрын дарга Оюунаа, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамны газрын дарга Сүхбат, Хот, хөдөөгийн сэргэлт газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хорооны ахлах мэргэжилтэн Буяндэлгэр, Эрүүл мэндийн яамны газрын дарга Оюунцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Мөнхнасан, мөн яамны газрын дарга Дондогдорж, мөн яамны шинжээч Болдбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ахлах шинжээч Эрдэнэцэцэг, Сангийн яамны газрын дарга Золбоо, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ахлах шинжээч Эрдэнэ, Эрчим хүчний яамны ахлах шинжээч Энхтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны ахлах мэргэжилтэн Чулуунчимэг, Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн захирал, доктор, профессор Баттүвшин нар өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Эцсийн хэлэлцүүлгийг, танилцуулга хийе.

Засгийн газраас 2024 оны 05 сарын 28-ны өдөр Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Их Хурал 06 сарын 05-ны өдөр нэгдсэн чуулганаар хэлэлцсэн. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн байгаа.

Байнгын хороо 06 сарын 05-ны өдрийн хуралдаанаараа “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлгийг Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан явуулж байна.

Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусгаад төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй загварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргэсэн байгаа.

Тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Танилцуулгатай холбогдуулаад асуух гишүүн байна уу? Алга байна.

Сая би танилцуулгад хэлсэн. Тэгээд энэ түрүүн бид нар ярихдаа бүс нутаг гэснийг бүс гээд адилхан болгож жигдлэх, шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэр технологийн паркийн тоо гэсэн хариуцлага гэсэн хэсгийн хариуцах байгууллагад Засгийн газар гэж, бас

нэг бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гэж бусад бүстэй адилхан нийцүүлж, түрүүчийн хэлэлцсэн ёсоороо жигдлээд оруулаарай гэдгийг ажлын хэсгийнхэнд хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж дууссан. Асуулт байхгүй.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд боллоо, тийм ээ, санал хураах билүү, хураахгүй тийм ээ.

Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулгыг Сүхбаатар гишүүн хийнэ.

Энэ хуралдаан манай энэ удаагийн Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хамгийн сүүлчийн хуралдаан болж таарч байгаа. Үүнээс хойш дахиж асуудал хэлэлцэх ийм шалтаг шалтгаан гарахгүй болов уу гэж бодож байна.

Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороонд хамтарч ажилласан бүх гишүүддээ, түүн дотор бүр ялангуяа эмэгтэй гишүүддээ, бусад намын төлөөлөл болж орсон Доржханд гишүүндээ, Адъяасүрэн гишүүндээ, Пүрэвдорж гишүүн, Батсуурь гишүүн нартаа баярлалаа.

Манай Төрийн байгуулалтын байнгын хороогоор энэ удаагийн чуулганаар үнэхээр Монгол Улсын төрийн байгуулалттай холбоотой үндсэн өөрчлөлтүүдийг хийсэн маш том хуулиуд орж батлагдсан. Үндсэн хууль, Намын хууль, Сонгуулийн хууль, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд дунд болоод урт хугацаанд

Монгол Улс хөгжих эрх зүйн зохицуулалтын гол зүйлүүдийг бид нар хамтарч хийсэн гэж ингэж ойлгож болно. Бүгдээрээ их хариуцлагатай сайн ажилласан.

Ер нь ч ингээд бусад Байнгын хороотойгоо харьцуулж ярих нь хаашаа юм. Манай Байнгын хороо бол зарласан цагтаа цуглаж, хэлэлцсэн асуудлаараа маш үр дүнтэй ярилцлага явуулж, санал онолоо нэгтгэж ингэж явж ирсэн, бүх гишүүддээ талархлаа.

Нэр дэвшиж байгаа гишүүддээ сонгуульд нь амжилт хүсье.

Бусад гишүүддээ цаашдын ажил, амьдрал, карьерт нь хамгийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Баярлалаа, та бүхэнд.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан өндөрлөж байна.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ